

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДЭД ҮЗҮҮЛЭХ ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛСНИЙ ХЭМЖЭЭ

Ерөнхий үндэслэл

Харилцаа холбооны зохицуулах хороо нь “ Харилцаа холбооны тухай” хуулийн 9.1.11-д заасан эрхийнхээ дагуу Дэд бүтцийн сайдын 2003 оны 39 тоот тушаалаар батлагдсан “ Тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үзүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох журам”-ыг үндэслэн зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтооно.

Нэг. Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ

- 1.1 Зохицуулалтын үйлчилгээний хөлсийг тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрхлэх үйлчилгээний тоо, төрөл, үйлчилгээний хамрах хүрээ, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйлчилгээ эрхлэх бизнесийн орчин зэргийг харгалзан ялгавартай тогтооно.
- 1.2 А ангилалын харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүнийг ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үзүүлэх зохицуулалтын үйлчилгээний жилийн хөлсийг дараах байдлаар тогтооно.

№	Тусгай зөвшөөрлийн төрлүүд	Орлого / сая.төгрөг /	Зохицуулалтын үйлчилгээний хөлс / мян.төг /
1.	Мэдээлэл холбооны хотын сүлжээ байгуулах түүнийг ашиглах	3000,0 хүртэл 3000,0-5000,0 5000,0-10000,0 10000,0-аас дээш	250,0 350,0 450,0 орлогоос 0,05 коэф-ээр
2.	Мэдээлэл холбооны бүсийн сүлжээ байгуулах түүнийг ашиглах	3000,0 хүртэл 3000,0-5000,0 5000,0-10000,0 10000,0-аас дээш	250,0 350,0 450,0 орлогоос 0,05 коэф-ээр
3.	Мэдээлэл холбооны хот хоорондын сүлжээ байгуулах түүнийг ашиглах	3000,0 хүртэл 3000,0-5000,0 5000,0-10000,0 10000,0-аас дээш	250,0 350,0 450,0 орлогоос 0,05 коэф-ээр
4.	Мэдээлэл холбооны улс хоорондын сүлжээ байгуулах түүнийг ашиглах	3000,0 хүртэл 3000,0-5000,0 5000,0-10000,0 10000,0-аас дээш	250,0 350,0 450,0 орлогоос 0,05 коэф-ээр

5.	Үүрэн телефон холбооны сүлжээ байгуулах, түүнийг ашиглах		Б ангиллын тусгай зөвшөөрлийн 5-д заасан үйлчилгээний хөлсөнд багтана
6.	Радио телевизийн сүлжээ байгуулах түүнийг ашиглах		Б ангиллын тусгай зөвшөөрлийн 7,9-д заасан үйлчилгээний хөлсөнд багтана
7.	Шуудан холбооны хотын сүлжээ байгуулах, түүнийг ашиглах	50,0 хүртэл 50,0-100,0 100,0-аас дээш	100,0 150,0 орлогоос 0,002 коэф-ээр
8.	Шуудан холбооны бүсийн сүлжээ байгуулах, түүнийг ашиглах	50,0 хүртэл 50,0-100,0 100,0-аас дээш	100,0 150,0 орлогоос 0,002 коэф-ээр
9.	Шуудан холбооны хот хоорондын сүлжээ байгуулах, түүнийг ашиглах	50,0 хүртэл 50,0-100,0 100,0-аас дээш	100,0 150,0 орлогоос 0,002 коэф-ээр
10.	Улс хоорондын шуудангийн сүлжээ байгуулах, түүнийг ашиглах	50,0 хүртэл 50,0-100,0 100,0-аас дээш	100,0 150,0 орлогоос 0,002 коэф-ээр

1.3 МЦХ ХК, Мобиком ХХК, Скайтел ХХК-ууд Засгийн газар хоорондын гэрээгээ тогтоосон хэмжээгээр, Юнител ХХК, Жимобайл ХХК-ууд тусгай зөвшөөрлийн гэрээнд заасан хэмжээгээр тухайн жилийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг тус тус төлнө.

1.4 Шинээр хөдөлгөөнт холбооны сүлжээ байгуулан, түүнийг ашиглах, радио телевизийн сүлжээ байгуулах, түүнийг ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үзүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсийг Б ангилалын үүрэн телефон холбооны үйлчилгээ эрхлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсөнд багтаан авна.

1.5 Шинээр утасгүй суурин телефон холбооны сүлжээ байгуулан, түүнийг ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигчид нь эхний жилд зохицуулалтын үйлчилгээний хөлсөнд 50000,0 мянган төгрөг төлөх бөгөөд дараагийн жилээс тусгай зөвшөөрлийн А,Б ангилалд заасан зохицуулалтын үйлчилгээний хөлсийг төлнө.

1.6 Мэдээлэл холбооны болон шуудангийн сүлжээ байгуулах, түүнийг ашиглах үйлчилгээг өргөжүүлэх, зах зээлд чөлөөтэй өрсөлдөх нөхцлийг бүрдүүлэх үүднээс А1 ангиллын тусгай зөвшөөрлийн зохицуулалтын үйлчилгээний хөлсний нийт дүнгээс эхний жилд 20 хувиар, А2 ангиллын тусгай зөвшөөрлийн зохицуулалтын үйлчилгээний хөлсний нийт дүнгээс эхний жилд 10 хувиар тус тус хөнгөлөлт үзүүлнэ.

1.7 Б ангиллын Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшчдэд үзүүлэх зохицуулалтын үйлчилгээний жилийн хөлсийг дор дурьдсан хэмжээгээр тогтооно.

Зохицуулалтын үйлчилгээний төрлүүд	Улсын нутаг дэвсгэрийг хамарсан	Улаанбаатар	Бусад аймгийн төв	Сум суурин газарт
1. Улс хоорондын ярианы үйлчилгээ эрхлэх	2000,0			
2. Бүсийн хэмжээнд ярианы үйлчилгээ эрхлэх	Бүс тус бүрт 1200,0			
3. Хот хоорондын ярианы үйлчилгээ эрхлэх	2000,0		300,0	50,0
4. Хотын дотор ярианы үйлчилгээ эрхлэх	4800,0	1800,0	300,0	50,0
5. Үүрэн телефон холбооны үйлчилгээ эрхлэх	55000,0	500,0	150,0	50,0
6. Утасгүй телефон холбооны үйлчилгээ эрхлэх / WLL, PHS гэх мэт /	4000,0	500,0	100,0	50,0
7. Телевизийн нэвтрүүлгийг нэвтрүүлэх, дамжуулах үйлчилгээ эрхлэх	3000,0	500,0	100,0	50,0
8. Кабелийн телевизийн үйлчилгээ эрхлэх / CATV, MMDS, LMDS гэх мэт /	1900,0	700,0	150,0	50,0
9. Мультимедиа үйлчилгээ эрхлэх - Хөдөлгөөнт телевиз - Интернет протоколд суурилсан телевиз		2400,0 2400,0	300,0 300,0	
10. Радио өргөн нэвтрүүлэг нэвтрүүлэх, дамжуулах үйлчилгээ	1500,0	200,0	90,0	50,0
11. Улс хоорондын суваг, шугам түрээслүүлэх үйлчилгээ эрхлэх	7000,0	2000,0	500,0	
12. Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх	400,0	300,0	200,0	
13. Шуудангийн үндсэн үйлчилгээ эрхлэх	300,0	300,0	50,0	
14. Шуудангийн нэмэлт үйлчилгээ эрхлэх	100,0	50,0	30,0	
15. Шуудангийн логистик үйлчилгээ эрхлэх	300,0			
16. Улс хоорондын шуудангийн үйлчилгээг чиглэсэн маршрутаар эрхлэх	300,0	300,0	150,0	50,0
17. Харилцаа холбооны үйлчилгээг дамжуулан хүргэх үйлчилгээг эрхлэх / Сансарын хөдөлгөөнт холбооны үйлчилгээ эрхлэх, Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх, Интернетийн дахин дамжуулах үйлчилгээ эрхлэх, Дотоод хэрэглээний сүлжээгээр нийтийн үйлчилгээ эрхлэх/	800,0	200,0	50,0	

18.Интернэтийн үйлчилгээ эрхлэх	500,0	300,0	100,0	30,0
19. Харилцаа холбооны дэд бүтцийн суурилуулалт, засвар, угсралтын ажил үйлчилгээ эрхлэх Үүнд: - дотоод холбооны сүлжээний суурилуулалт, засварын үйлчилгээ - холбооны кабель шугамын суурилуулалт, засвар, угсралтын ажил үйлчилгээ эрхлэх -барилгын дотор холбооны монтаж, угсралт - Цамхаг түүн дээрх холбооны тоног төхөөрөмж угсрах суурилуулах	150,0	100,0	50,0	
20. Мэдээлэл лавлагааны зориулалттай тусгай дугаарын менежментийн үйлчилгээ эрхлэх	150,0	100,0	50,0	

- 1.8 Зохицуулалтын үйлчилгээний хөлсийг 1.7-д заасан хэмжээгээр тооцож авахдаа Улаанбаатар хот, 10-аас дээш аймагт үйлчилгээ эрхэлж байвал улсын нутаг дэвсгэрийг хамарсан гэж тооцно.
- 1.9 Б ангиллын тусгай зөвшөөрлийн **7,8,10**-д заасан үйлчилгээнүүдийг 1-3 хүртэл аймагт эрхлэх бол аймаг тус бүрээр, 4-7 аймагт эрхлэх бол тухайн төлбөрийг 90 хувиар, 8-10 аймагт эрхлэх бол 95 хувиар тус тус зохицуулалтын үйлчилгээний хөлсийг тооцно.
- 1.10 Улаанбаатар хотын аль нэг дүүрэгт үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчээс авах зохицуулалтын үйлчилгээний хөлсийг аймгийн төвд үйлчилгээ эрхлэгчийн жишигээр тооцно.
- 1.11 Хөдөө орон нутагт үйлчилгээ хүрээгүй газарт үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих зорилгоор тухайн үйлчилгээг нэг аймгийн хэдэн суманд эрхэлж байгаагаас хамаарахгүйгээр нэг суманд үйлчилгээ явуулах хэмжээний төлбөрийг авна.
- 1.12 Интернетийн үйлчилгээг дэмжих , интернэтийн хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор интернэтийн үйлчилгээ эрхлэх Б ангиллын тусгай зөвшөөрлийн зохицуулалтын үйлчилгээний хөлснийг эхний 2 жилд 40 хувиар хөнгөлөлт үзүүлнэ.
- 1.13 Тусгай дугаарын менежментийн үйлчилгээг дэмжих, зах зээлд чөлөөт өрсөлдөөнийг нэвтрүүлэх зорилгоор Б ангиллын тусгай зөвшөөрлийн 20-д заасан зохицуулалтын үйлчилгээний төлбөрийг эхний 2 жилд тогтоосон хэмжээгээр авч 3 дахь жилээс зохицуулалтын үйлчилгээний хөлсийг нэмэгдүүлэн тогтооно.

Хоёр. Дугаарлалтын зохицуулалтын үйлчилгээ

- 2.1 Улс хоорондын ярианы угтвар дугаарын зохицуулалтын үйлчилгээний хөлсийг эхний жил 50000,0 мянган төгрөгөөр, дараагийн жилээс энэ журмын 2.2 дугаар зүйлийн “Б”-ын 1-д заасан хэмжээгээр тооцно.
- 2.2 Дугаарлалтын зохицуулалтын үйлчилгээний жилийн хөлсийг дараах байдлаар тогтооно.

Дугаарлалтын төрлүүд	Жилийн зохицуулалтын хөлсний хэмжээ / мянган төгрөг /
А. Тусгай дугаар 1. Нийгмийн үйлчилгээний зориулалттай дугаарууд 2. Сүлжээний техник, технологийн ашиглалт болон нэмэлт үйлчилгээний зориулалттай дугаарууд 3. Тусгай дугаарт мессежийн үйлчилгээний дугаар 4. Мэдээлэл лавлах үйлчилгээний 5. Интернэтийн үйлчилгээний зориулалттай	Төлбөргүй Дугаар бүр 50,0 Дугаар бүр 0,05 Дугаар бүр 500,0 Дугаар бүр 200,0
Б. Угтвар дугаар 1. Улс хоорондын ярианы гарцын угтвар дугаар / 001,002,003,004 гэх мэт/ 2. Хот хоорондын ярианы сүлжээний угтвар дугаар 3. Интернэт протоколд суурилсан улс хоорондын ярианы үйлчилгээний угтвар дугаар / 007.79xx xxxx /	Улс хоорондын ярианы орлогын 0,019 хувь Хот хоорондын ярианы орлогын 0,001 хувь Дугаар тус бүр 0,1
В. Сүлжээний дугаарлалт 1. Цахилгаан холбооны сүлжээний 10.000 хэрэглэгчийн дугаар / нэг багцын жилийн төлбөр / 2. Цахилгаан холбооны сүлжээний 100.000 хэрэглэгчийн дугаар / нэг багцын жилийн төлбөр / Цахилгаан холбооны сүлжээний 1.000.000 хэрэглэгчийн дугаар / нэг багцын жилийн төлбөр /	120,0 1200,0 12000,0

2.3 Харилцаа холбооны салбарт тогтвортой үйлчилгээ эрхлэгчийг дэмжих үүднээс 2-оос дээш жил тусгай дугаарыг ашиглаж байгаа бол 3 дахь жилээс эхлэн жилийн төлбөрийг 10 хувиар хөнгөлнө.

2.4 Аймгийн төвд мэдээлэл, лавлах үйлчилгээний зориулалтаар тусгай дугаар ашиглах бол зохицуулалтын үйлчилгээний хөлсийг 50 хувийн хөнгөлөлттэй тооцно.

2.5 Сум суурин газарт тусгай дугаарыг ашиглан үйлчилгээ эрхлэх бол зохицуулалтын үйлчилгээний хөлсийг 80 хувийн хөнгөлөлттэйгээр тогтооно.

2.6 Тусгай дугаарт мессежийн үйлчилгээний дугаарын багцыг үүсгэсэн үйлчилгээ эрхлэгч бүр дугаар тус бүрт 2.2-ийн А хэсгийн 5-д заасны дагуу зохицуулалтын үйлчилгээний хөлсийг төлнө.

Гурав. Бусад

3.1 Тусгай зөвшөөрлийн ангиллын гурав дахь хэсэгт заасан үйлчилгээнүүдийг бүртгэн бүртгэлийн гэрчилгээ олгох, сунгах зохицуулалтын үйлчилгээний хөлс 50000 төгрөгийг эхний жилд авна.

3.2 Жил бүрийн мөнгөний ханшийн өөрчлөлттэй уялдуулан зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг өөрчлөн тогтоож болно.

/Энэ хөлсний хэмжээнд 2006 оны 01, 2007 оны 58, 59 тоот, 2009 оны 20, 35 дугаар тогтоолоор орсон нэмэлт, өөрчлөлтийг тусгасан болно./

----- о О о -----